



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/63

Хөхбүрд

Сурагчдад зориулсан хичээлийн хэрэгсэл олгоход шаардагдах төсвийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр журмын 2 дугаар зүйлийн 2.1.6, Төсвийн тухай хуулийн 16.5.5 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023-2024 оны хичээлийн шинэ жилд Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид элсэж буй сурагчдад зориулан хичээлийн хэрэгсэл олгосугай.

2.Хичээлийн хэрэгсэл олгоход шаардагдах 1.291.200 (Нэг сая хоёр зуун ерэн нэгэн мянга хоёр зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), Нягтлан бодогч (Л.Алимаа) нарт зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОРХОНТУУЛ



642301185